



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: goviumber@audit.gov.mn

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НӨХӨН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ АЙМГИЙН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ДАРГА
Г.БАТСУУРЬ ТАНАА

2023.04.18 № 100
танай _____ -ны № _____ -т

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Аймагийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны нөхөн сонгуульд оролцох Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймагийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050"-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймагийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон "Алсын хараа-2050", холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Монгол ардын намын Аймагийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3. дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Монгол ардын намын мөрийн хөтөлбөр /.....хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Аймагийн Сонгуулийн хороонд

Хавсралт 5... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА

008020224

